



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

Г АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ТӨМӨРТОГОО ТАНАА

2017.02.02 № 01/06 ДУА 2017/16/СТА-ТЦЗ

Г

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Адаацаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны санхүүгийн тайланд аudit хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргад чөлөөтэй байх хугацаанд нь 698,795.00 /Зургаан зуун ерөн найман мянга долоон зуун ерөн тав / төгрөгийн цалинг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийтөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т /Ажсийн цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгон/ заасныг тус тус зөрчсөн байна..

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчилтэй барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчилтэй арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нолоотэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийн хөрөнгийг хууль, журамд зааснаас бусад зориулалтаар ашиглаж, зарцуулахгүй байх;

0900000011

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 05 дугаар сарын 05-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Адаацаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Төмөртогоо, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт даалгав.

## АЛБАН ШААРДЛАГЫГ

### ӨГСӨН<sup>1</sup>:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

### ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА



Л.ТӨМӨРТОГОО

НЯГТЛАН БОДОГЧ



Б.ЭНХЖАРГАЛ

---

<sup>1</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанд ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна/